



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-12
<i>1. “Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай” Түр хорооны тогтоолын төсөл</i>	5-8
<i>2. “Хянан шалгах түр хорооны даргыг томилох тухай” Түр хорооны тогтоолын төсөл</i>	8-12

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 10 дугаар сарын 10-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Х.Нямбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 23 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Жаргалмаа, Т.Доржханд, О.Цогтгэрэл;
Чөлөөтэй: Г.Ганболд, Ж.Сүхбаатар.

Нэг. “Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, референт М.Мандхай, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Түр хорооны дарга Х.Нямбаатар Түр хорооны даргаас чөлөөлөгдөх хүсэлтээ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Түр хорооны дарга Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Түр хорооны дарга Х.Нямбаатар “Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай” Түр хорооны тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Х.Нямбаатар: “Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хянан шалгах түр хорооны даргыг томилох тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, референт М.Мандхай, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярыг Түр хорооны даргад нэр дэвшүүлж байгаа тухай танилцуулав.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Түр хорооны даргад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Түр хорооны дарга Х.Нямбаатар “Хянан шалгах түр хорооны даргыг томилох тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Х.Нямбаатар: “Хянан шалгах түр хорооны даргыг томилох тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны даргаар томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хуралдааныг даргалав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Түр хорооны хуралдаан 16 цаг 59 минутаас 17 цаг 15 минут хүртэл хаалттай горимд шилжин хуралдав.

Нээлттэй хуралдаан 37 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн **ирцтэйгээр** 17 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн
Чингис хаан” танхим 16 цаг 23 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Нямбаатар: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын. Ганбат гишүүн ороогүй байна уу?

Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2023 оны 07 сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэд мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын гишүүн Энхтайваны Бат-Амгалан, Хишгээгийн Нямбаатар, Мөнхөөгийн Оюунчимэг, Баттөмөрийн Энхбаяр, Сайнхүүгийн Ганбаатар, Дашидондогийн Ганбат нарын гишүүд ирсэн байна.

Бадарчийн Жаргалмаа гадаадад томилолттой, Тогмидын Доржханд гадаадад томилолттой, Одонгийн Цогтгэрэл гишүүн томилолттой байна. Их Хурлын гишүүн Жамьянхорлоогийн Сүхбаатар ирж байна гэдэг ийм мэдээлэл өгсөн байна. Ганболд

гишүүнтэй холбогдсон уу? Ганболд гишүүнтэй холбогдож чадаагүй байна.

Ингээд гишүүдийн ирц бүрдэж, 54,5 хувьтай байгаа учраас өнөөдрийн хурлаа эхэлье.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх 4 асуудал байна.

1 дүгээрт, “Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл,

2-т нь, “Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл,

3-д нь, “Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төсөл,

4-д нь, “Хянан шалгах түр хорооны шинжээч томилох тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг тус тус хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байхгүй байгаа тул дээр дурдсан 4 асуудлаасаа эхнийхээ асуудлыг хэлэлцэж эхэлье.

Эхний асуудал бол миний бие Хянан шалгах түр хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж байгаа. Энэ тухай би хүсэлтээ уншъя.

Хянан шалгах түр хороонд. Нийтийн эрх ашгийг хөндсөн нүүрсний гэх асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолын төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг миний бие нэр бүхий гишүүдийн хамт санаачлан боловсруулж, Улсын Их Хурлын даргад

2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог байгуулсан.

Хянан шалгах түр хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолоор Түр хорооны даргаар сонгогдон ажиллаж байна. Цаашид Хянан шалгах түр хорооны даргын албан үүргийг гүйцэтгэх боломжгүй болж байгаа тул үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаж байгаа тул хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэж өгнө үү гэсэн ийм хүсэлтийг миний бие гаргаж байна. Хянан шалгах түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Нямбаатар.

Уг асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Ганбат гишүүн асуух асуулттай.
Ганбат гишүүний микрофоныг өгье.

Д.Ганбат: Яах вэ, ерөнхийдөө анх Нямбаатар сайдыг энэ нүүрсний түр хороог ахалж ажиллахад бас нэлээн эргэлзэж байсан. Энэ хооронд ажлын төлөвлөгөө гараад ажиллаж байгаа байдал, энэ тэрийг нь харахад ямар ч байсан Хууль зүйн сайд нь энэ түр хороогоо ахлаад ингээд ажиллаж байгаа нь, ажиллах гэж байгаа, ажиллаж байгаа нь энэ Засгийн газрын бодлого шийдвэр. Энэ юм нь одоо яаж хөрсөн дээр буух вэ гэдэг ийм хариуцлагаа

хүлээгээд ажиллах гэж байгаа юм байна гэж ойлгосон.

Та ингээд өөрийн хүсэлтээр ингээд нүүрсний түр хорооны даргаасаа больж байна. Энэ хугацаанд бас нэлээн ажиллаад зохих ёсны мэдээлэл төлөвлөгөө гаргаад ингэчихсэн байгаа байх аа. Дараагийн хүн чинь ажиллаад тэр талаар санал бодол зөвлөгөө тийм ээ, энэ юмыг яаж сайн хийх вэ, олон түмэнд мэдэх эрхийг нь яаж хангах вэ гээд энэ дээр та ямар бодолтой байна вэ? Яаж ажиллавал зүгээр байна, ямар байвал зүгээр байна?

Нөгөө талаар энэ чинь түр хороог 6 сарын хугацаатай байгуулдаг. Ингээд дарга цэрэг нь солигдоод энэ бол танай намын чинь бодлого, Засгийн газрын чинь өөрсдийн чинь бодлого л байгаа байх л даа. Ингээд тэр бодлогынхоо дагуу солигдож бариад ингээд эхлэхээр нөгөө 6 сарынхаа хугацаанд дараагийн хүн чинь, түр хороо чинь ажиллаад, энэ олон улс орон даяар, улс орон даяар байтугай бараг нэлээн газар авчихсан энэ асуудлыг шийдэх цаг хугацааны хувьд ямар боломжтой вэ? 6 сарын хугацаа бага л хугацаа юм шиг байгаа юм. Энэ том хэрэг дээр бол, гэж ойлгож байгаа. Тэгээд таны бодлыг энэ дээр нэг сонсоодохье.

Х.Нямбаатар: Баярлалаа, Ганбат гишүүнд. Миний бие энэ 4 дэх өдөр Пүрэв гарагт Улсын Их Хурлын даргад өргөдлөө гаргаж байгаа. Улсын Их Хурлын гишүүний үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх ийм улс төрийн шийдвэр гарсан. Үүнийг харгалзан үзэж Улсын Их Хурлын гишүүнийхээ үүрэгт ажлыг шилжүүлэн өгөхөөр ингээд хүсэлт гаргаж байгаа. Тэгэхээр цаашид миний бие энэ гишүүний бүрэн эрх дуусгавар болж байгаатай холбоотойгоор Хянан шалгах түр хороонд ажиллах энэ хууль, эрх зүйн боломжгүй болж байгаа.

Бид нар 07 сарын 05-нд чуулган завсарлахын өмнө өдөр түр хороогоо

байгуулсан. Сая чуулган эхэлмэгц Хянан шалгагч 5 хүнээ томилсон. Хянан шалгагч 5 хүнээ бид 5 чиглэлээр ажиллуулж байгаа. Тухайлах юм бол нүүрсний энэ томоохон компаниуд болох Эрдэнэс тавантолгой, Тавантолгой ХК-уудын худалдан авалттай холбоотой материалуудыг татаж авъя гэдэг хүсэлтээ холбогдох байгууллагууд нь гаргаад ажиллаж байгаа.

Үүнээс гадна нүүрсний экспорттой холбоотой гэрээ хэлцлүүдэд дүн шинжилгээ хийх, анх ашиглалтын лиценз олгогдсоноос хойш уулын ажлын төлөвлөгөөний дагуу нүүрсний олборлолтын үйл ажиллагаа явагдсан эсэх, уурхайн энэ нөгөө хөгжлийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явагдаж байгаа эсэх, нүүрсний тээвэртэй холбоотой гэрээ хэлцлүүд гээд ингээд хянан шалгагч нар зохих чиглэлүүдийн дагуу ажиллаж байгаа. Энэ хянан шалгагч нарыг ХЗДХЯ дээр өрөө тасалгаа гаргаж өгөөд, ажиллах нөхцөл бас боломжуудыг нь хангаад ажиллаж байгаа.

Тодорхой мэдээллүүд цуглуулаад материалууд дээр ажиллаж байгаа. Одоо энэ хүмүүс энэ шинжээчээр хянан шалгагчаар томилогдсон хүмүүс үндсэндээ Энхбаяр дарга болон дараагийн энэ Хянан шалгах түр хорооны гишүүдтэй хамтарч ажиллах ийм чиг үүрэгтэйгээр ажиллаж байгаа.

Дээр нь манай түр хорооны ажлын албаныхан өдөр тутмын удирдлагаар хангаад ажиллаж байгаа. Өөрөөр хэлбэл төрийн ажил тасралтгүй явагдаж байгаа гэдгийг хэлье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөл уншъя.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тогтоол. Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх

тухай. Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг үндэслэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1. Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатарын өөрийнх нь хүсэлтийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хяналт шалгалтын түр хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Үг хэлэх гишүүд. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуух асуулт, үг хэлэх гишүүд байхгүй тул санал хураалт.

Энэ гишүүд орж ирэх үү. Оюунчимэг гишүүн, Ганбат гишүүн 2-ыг орж ирсэн хойно санал хураалт явуулъя.

Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 83,3 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Хянан шалгах түр хорооны даргыг чөлөөлөх тухай тогтоолын төсөл дэмжигдсэнтэй холбогдуулан **Түр хорооны даргыг сонгох тухай.**

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5-д Түр хорооны даргыг Түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж заасан. Ингээд Түр хорооны даргад нэр дэвшүүлэх саналтай гишүүд байвал нэрсээ өгье.

Би Түр хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаярын нэрийг дэвшүүлж байна.

Өөр нэр дэвшүүлэх хүмүүс байвал кнопоо даръя. Өөр хүн дэвшүүлэх хүн байсангүй.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаярыг нэр дэвшүүлж байгаатай холбогдуулж, асуух асуулттай гишүүд байна уу.

Ингээд тийм, Түр хорооны даргад Баттөмөрийн Энхбаярыг дэвшүүллээ. Ингээд нэр дэвшүүлж дууслаа.

Нэр дэвшигчтэй холбогдуулж, Түр хорооны даргад нэр дэвшиж байгаатай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Кнопоо даръя. Алга байна.

Үг хэлэх. Ганбат гишүүн.

Д.Ганбат: Хөгжлийн банкны түр хороон дээр бол анхны түр хороог манай Энхбаяр гишүүн удирдаж ажилласан. Энэ бол нэлээн жишиг болсон сайн ийм сонсгол болсон гэж үзэж байгаа. Нийгэм ч тэгж хүлээж авсан байх. Түүний үр дүн ямар байсан бэ гэвэл асуудалтай л даа. Үүний үр дүн дээр 2 дахь түр хороогоо та даргалахаар ингээд нэр дэвшигдэж байна.

Тэгэхээр энэ түр хорооны үр дүн маань ямар байх вэ? Өмнөх түр хорооны сонсгол бол сайн болсон. Бүгд тийм бодолтой байгаа байх. Нийгэм ч тэгж хүлээж авсан. Үр дүнгийн талаар бол та ямар бодолтой байна вэ. Энэ чинь аливаа хийсэн ажил чинь дагаад үр дүн байх ёстой л доо. Авлигатай тэмцэх асуудал, нөгөө гэмт хэргээс ял завиших энэ бүх юм байхгүй л байх ёстой. Олон түмний анхааралд оруулсан ийм зүйлүүд байдаг. Ингээд түр хороо би Нямбаатар гишүүнээс өмнө асуусан л даа. Энэ ажлыг дараагийн Түр хорооны дарга амжуулж чадах уу, үгүй юү? Аль 7, 8 сард байгуулсан ийм түр хороо. 6 сарын хугацаатай л байгуулагддаг. 1 удаа хугацааг нь сунгаж болдог байх, хуулиараа тийм байгаа байх.

Тэгээд аягүй хүлээлттэй байна, нийгэм бол, энэ нүүрсний түр хороон дээр. Өмнөх түр хороо нь бол тийм амжилттай болж чадаагүй. Нийгмийн хүсэн хүлээсэн шиг. Энэ түр хороо бол тэр нийгмийн хүсэн хүлээгээд байгаа хуулийнх нь дагуу энэ олон жилийн явсан, тэр тусмаа экспортын гол бүтээгдэхүүн болсон нүүрс ямар замаар хэний гарт очоод, яаж дуусдаг байсан. Хэрвээ энэ нүүрс маань өөрөө яг гардаг газраа гараад, төлдөг татвараа төлөөд ингэж явж чадсан бол өнөөдөр бид нар багш нарынхаа цалинг, эмч нарынхаа цалинг, энэ эргүүлийнхээ цагдаа, төрийн албан хаагчдын цалинг бол нэг мянган доллараар тэр аваачих боломж байлаа. Энэ их боломж байхгүй байна. Энэ дээр Түр хороог даргалах гэж байгаа нэр дэвшсэн, бодвол энэ Засгийн газрын

олонхын бодлого л байх л даа, цаана нь. Бодлогоор бас таны нэрийг дэвшүүлж байгаа болов уу гэж ойлгож байна. Энэ дээр та ямар байр суурьтай байна вэ гэсэн ийм асуултыг асууя.

Х.Нямбаатар: Ганбат гишүүний асуултад Энхбаяр гишүүн хариулна. Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхий сайд, ер нь нүүрсний хулгайн асуудал дээр нэг мөр олон талаас нь яаралтай, энэ ондоо багтаагаад нээлттэй сонсгол хийж, ард түмэнд бодит үнэнийг илчлэхийг үүрэг даалгавар болгож, энэ итгэлээр бас Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ажиллуулах гэж байгаа гэдэг асуудлаа Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд бас танилцуулсан байдаг.

Ер нь парламентын хяналтын асуудал бол та бидний хамтын үр дүн байгаа. Энэ бол нэг хүний ийм ажиллагаа байдаггүй. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт орж, парламентын хяналт, тэр дотроо хяналт шалгалтын түр хороо байгуулах эрх зүйн үндэс Үндсэн хуульд нутагисан. Үүний дагуу мөн та бид бас хамтдаа 2022 оны 01 сард Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль баталж, Хөгжлийн банкны хянан шалгах түр хороонд бас Ганбат гишүүн бид бас хамтдаа орж ажиллаж, үр дүн гаргасан.

Нүүрс дээр ч гэсэн бид бас хамтдаа мөр зэрэгцээд сууж байна. Ер нь нэг онцлог парламентын түр хороонд байгаа юм байна лээ. Парламентын Хөгжлийн банкны хянан шалгах түр хороо бол бүтэн жил ажилласан. Энэ дээр гаргачихсан нотлох баримт асуудлууд бол Монголын ард түмэнд шууд явсан. Бүх орон даяар шууд явагдсан, ил тод нээлттэй байдал хангагдсан.

Тэгэхээр энэ үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал бол өөрөө ямар, одоо ард

түмэн өөрөө үнэлэлт дүгнэлтээ өгч байгаа байх гэж би бол боддог. Үүнийг бол хийн шүүн таслах ажиллагаатай холбож ойлгох нь бас их учир дутагдалтай. Яагаад гэхээр парламент бол шүүн таслах эрх мэдлийг бол хэрэгжүүлэхгүй. Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх л хэрэгжүүлнэ.

Нөгөө талаараа шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн хэнбугай ч хөндлөнгөөс оролцож нөлөөлөхийг Үндсэн хуулиар хориглодог. Үндсэн хуулиар. Хэрвээ үүнийг зөрчих юм бол эдгээр хүмүүст ҮХЦ өөрөө хариуцлага тооцох асуудал Үндсэн хуульд бас бичээтэй байдаг.

Тийм учраас энэ талаар миний бие өөрөөр хэлбэл шүүхийн шүүн таслах ажиллагааны талаар ямарваа нэгэн байр суурь илэрхийлэхээс шууд түдгэлзэнэ. Яагаад гэхээр энэ асуудал шүүхээр бас эцэслэгдээгүй байгаа. Анхан шатын шүүхийн шийдвэр л гарчхаад явж байгаа. Давж заалдах шатаар үргэлжилнэ. Хяналтын шатаар үргэлжилнэ. Тийм учраас аливаа хэлбэрээр байр суурь илэрхийлэх юм бол тэр тусмаа Хууль зүй, дотоод хэргийн сайд болчхоод байгааг энэ агиинд илэрхийлэх юм бол энэ нь өөрөө шүүхийн шүүн таслах үйл ажиллагаанд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн нөлөөлсөн, хөндлөнгөөс оролцсон ийм Үндсэн хуулийн үр дагавар үүсэх учраас та үүнийг бас ойлгож хүлээж авах хэрэгтэй. Би бас энэ байр сууриа хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандаж илэрхийлж байгаа.

Би бол үр дүнгээ өгсөн гэж боддог. Яагаад гэхээр ард түмний нүд нэгдчихсэн. Ард түмний нүдийг нээчихсэн байхгүй юу. Хулгайг тэр тусмаа том хэмжээний хулгайг, ямар хэмжээний бүлэглэл, яаж хэрхэн хийдэг вэ гэдэг схем зураглалыг бүрэн илчилсэн, бүтнээр нь илчилсэн. Ер нь энэ их олон юм ер нь энд илчлэгдсэн дээ, нээгдсэн дээ. Үүний үр

дагавар бол их олон байгаа. Ер нь цаашдаа ер нь гар хөлөө тавиад, энд тэнд тавиад хулгай зэлгий хийгээд 10 жилийн дараа ч ингээд мартагнуулж болдог юм байна гэдэг энэ юм бол цаашдаа байхгүй болж байгаа шүү гэдэг сигналыг бол өгчихсөн.

Нүүрсэн дээр яах вэ гэдэг дээр би бол томилогдох, эсэх асуудал шийдэгдээгүй байгаа учраас урьдчилж бол бас янз янзын их юм ярих бол бас зохисгүй байх л гэж бодож байна.

Х.Нямбаатар: Баярлалаа.

Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ нүүрсний хулгайн асуудал гэдэг бараг л зууны хэмжээний асуудал болчихоод байдаг. Нийтэд тархсан мэдээллээр ингээд үзэхэд бол энэ 76 гишүүний 17 нь ч байна уу, 12 нь холбогдсон гэж үзэж байгаа. Хэвлэл мэдээлэл, хуулийн байгууллагаас бол тэгж ярьж байна, зарлаж байна. Энэ нь Улсын Их Хурлын бараг 20 хувь нь холбогдсон гэсэн үг.

Тэгээд шинэ, хуучин 2 ажлаа өгч байгаа, болох гэж байгаа дарга 2-оос бол асуулт асуулаа. Тэгээд нийгэм бол энэ дээр бол маш их хүлээлттэй байгаа. Энэ нүүрсний түр хорооны эхнийх нь Түр хороо бол бүтэн жил ажиллах хугацаандаа тэр нийгмийн хүлээлтэд хүрч чадаагүй л дээ. Хүлээлтэд хүрч чадаагүй. Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн ийм хүнийг Түр хорооны даргаар ингээд цаанаас нь мэдээж хэрэг цаана нь бодлого байдаг байх, бодлого байгаа гэж үзэж байна. Ингээд тавьж байна гэдэг маань нэг ёсондоо удахгүй ингээд сонгуулийн жил гарах гэж байна. Эндээс бол ард түмэн ингээд харж байна. Яг нөгөө яриад байгаа шигээ энэ хулгай, авлига, албан

тушаалын хэрэгтэй тэмцэх гэж байна уу, үгүй юү гэдэг нь бол эндээс ингээд харагдаж эхлэх юм байгаа юм.

Тэгээд АН байхдаа бол тухайлбал би байхдаа бол тэр Тахарын алба гэдгийг байгуулж байсан. Дараа нь Ардын нам олонх болоод Тахарын албыг татан буулгасан. Энэ бол гэрч, хохирогчийг хамгаалах ийм үндсэн үүрэгтэй шүүх, шүүгчийг ч гэсэн бас бие даасан байдлыг нь хангах ийм рольтой байгууллага. Маршалын алба гэдэг. Тэгээд одоо бас нүүрстэй холбоотой асуудлаар бол нэлээн хэдэн хүн бол цагдан хорихт байгаа ийм асуудал байна. Монгол Улсын баатрууд, Монгол Улсын гавьяатууд, Эрдэнэс таван толгойн захирал байсан ийм хүмүүс, Улсын Их Хурлын дэд дарга нь ч гэсэн холбогдчихсон ингээд байж байна.

Тэгэхээр энэ хүмүүсийг бас гэрч, хохирогчийг хамгаалалтад авдаг тэр асуудлын дагуу ажиллуулбал энэ хүмүүс цаанаа байгаа энэ юмыг Улсын Их Хуралтай, энэ хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллаад, бүгдийг нь ил гаргахад бэлэн байна гэсэн ийм зүйлийг яриад байгаа. Тэгэхээр манай нүүрсний асуудлыг хэлэлцэх энэ түр хороо бол үүнийг бас бодолцох ёстой. Тэгээд олон түмэнд нээлттэй, ил байж байж тэр хүмүүс бас хараа хяналт, хамгаалалтад амь нас, эрүүл мэнд нь, ард талын гэр бүл нь ийм баталгаатай болох ийм баталгаа шаардаад байгаа юм уу гэж ойлгож байгаа.

Нэг хэсэг хамтран ажилласан гэмт хэргийг ил тод болгож өгсөн ийм хүмүүсийг бас ойлгож бас өгч байгаа ял дээр нь ч гэсэн багасгах ч юм уу ийм практик олон улсад ардчилсан бүх улс орнууд байдаг. Тэгэхээр бид нар бол энэ хүмүүсийг нэгэнт хамгийн сүүлийн шатны шүүх хурал нь болоогүй байгаа нөхцөлд бол энэ нүүрсний сонсголын түр хороон дээрээ дуудаж авчирч асуух бас шаардлагатай бол хамгаалалтад авах

ийм зүйлийг бол хэрэгжүүлэх нь зүйтэй юм гэж бодож байна.

Тэгээд энэ талаар бол манай хуучин дарга ч гэсэн бодож байсан байх. Шинэ дарга маань ч гэсэн бас энэ талаар бодох ёстой. Бид хэд ч гэсэн үүнийг дэмжиж ажиллах ёстой. Олон түмэнд бүх байдлыг нээлттэй болгож ийм шаардлагатай. Түүнээс биш одоо хэн нэгний бүлэглэл хоорондын ч юм уу, ямар нэгэн байдлыг нуун дарагдуулах ч юм уу, нөгөө хүмүүсийг эрүүл мэнд, амь нас, ар гэрийг нь эрсдэлтэй байдалд ... /минут дуусав/

Х.Нямбаатар: Ганбат гишүүн үг хэлж дууслаа. Ганбат гишүүн Эрүүгийн хуульд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хамтран ажиллах тухай зохицуулалт эрх зүйн хариуцлагаас хөнгөрүүлэх, чөлөөлөх ийм нөхцөлүүд бүгд зохицуулалтад хадгалагдаж байгаа.

2 дугаарт, гэрч, хохирогчийг хамгаалах манай үндэсний тогтолцоо хэвээрээ хадгалагдаж байгаа гэдгийг би бас хэлье.

Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаярыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 83,3 хувь нь дэмжлээ.

Санал хураалтаар дэмжлэг авсан тул Хянан шалгах түр хорооны даргыг сонгох тухай тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсгийг үндэслэн

Хянан шалгах Түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны даргаар Баттөмөрийн Энхбаярыг сонгосугай.

Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Тогтоолын төслийг 83,3 хувийн саналаар дэмжсэн байна.

Ингээд тогтоолын төсөл дэмжигдсэн. Тогтоолын төсөл батлагдлаа. Ингээд түр хорооны даргаар сонгогдсон Энхбаяр дарга таныг хурлаа даргалахыг хүсэж байна.

Б.Энхбаяр: Түр хорооныхоо гишүүдэд талархлаа илэрхийлье. Түр хорооны хуралдааныг үргэлжлүүлъя.

Түр хорооны хянан шалгагчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд тогтоолын төслийг тараасан.

Дараагийн хэлэлцэх асуудал.

17.08 цаг

**Түр хорооны хянан шалгагчийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах
шинжээч нарыг томилох тухай
тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

**Бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА**

Хянан шалгах түр хорооны хэлэлцэх энэхүү асуудал нь түр хорооны дотоод зохион байгуулалтын шинжтэй асуудал байгаа тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналыг гаргаж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэгт заасны дагуу дээрх саналын горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

66,7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэнтэй холбоотойгоор хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангая. 5 минут.

Б.Энхбаяр: Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Гишүүдэд баярлалаа.

Хуралдаан өндөрлөсөн.